



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
ДӨРӨВДҮГЭЭР СУРГУУЛЬ

# “ЗҮҮН ТАЛЫН НОГООН БАЙГУУЛАМЖ” ТӨСӨЛ



2026.04.20

## “ЗҮҮН ТАЛЫН НОГООН БАЙГУУЛАМЖ” ТӨСӨЛ

### НЭГ. ТӨСЛИЙН ХУРААНГУЙ

- 1.1. Төслийн нэр: “Зүүн талын ногоон байгууламж”
- 1.2. Төслийг хэрэгжүүлэх газар: Дархан-Уул аймгийн Дархан сумын 3-р баг IV сургууль
- 1.3. Төсөл хэрэгжүүлэх хугацаа: 2026.05 сар
- 1.4. Төсөл хэрэгжүүлэх байгууллага: Дархан-Уул аймгийн IV сургууль
- 1.5. Төсөл хариуцсан хүний нэр, албан тушаал: Дархан сумын IV сургуулийн захирал Д.Дэлгэрбаяр
- 1.6. Төслийг санхүүжүүлэгч байгууллага: Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
- 1.7. Төслийн нийт төсөв: 12,290,000₮
- 1.8. Төслийн багийн бүрэлдэхүүн:
  - IV сургуулийн захирал Д.Дэлгэрбаяр
  - IV сургуулийн нягтлан Л.Ганзориг
  - IV сургуулийн нярав С.Мэндбаяр
- 1.9. Төсөл санаачлагч: Аймгийн ИТХ-ын төлөөлөгч О.Энхзаяа
- 1.10. Төслийн хамрах хүрээ: Дархан-Уул аймгийн IV сургуулийн сурагч, эцэг эх, багш, ажилтан, олон нийт

### ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТАНИЛЦУУЛГА:

1969 онд Дархан хотын IV бага сургууль нэртэйгээр байгуулагдан 8 багш, 8 бүлэг, 311 сурагчтайгаар сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаагаа анх эхлүүлсэн бөгөөд 1974 онд найман жилийн сургалттай дунд сургууль болон өргөжсөн ба 2007 онд Япон улсын Жайка Олон улсын байгууллагын буцалтгүй тусламжаар 756 хүүхдийн суудалтай сургуулийн 3 давхар барилгыг хүлээн авч 12 жилийн тогтолцоонд шилжин бүрэн дунд сургууль болсон.


2023 онд 480 хүүхдийн хүчин чадалтай орчин үеийн стандартад нийцсэн иж бүрэн хичээлийн Б байрыг хүлээн авч сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг амжилттай сайн зохион байгуулж байна.



2025-2026 оны хичээлийн жил Дархан сумын 1,2,3-р багийн хамран сургах тойргийн 1359 сурагч буюу бага ангид 679, дунд ангид 511, ахлах ангид 169 сурагч нийт 41 бүлэгт амжилттай хичээллэж байна.

Нийт 103 багш, ажилтантай. Үүнээс захиргаа аж ахуйн 40 ажиллагсад, байгалийн ухааны заах аргын нэгдлийн 20 багш, бага ангийн заах аргын нэгдлийн 20 багш, нийгмийн ухааны заах аргын нэгдлийн 23 багш. Нийт багш нарын 42% нь мэргэшлийн зэрэгтэй бөгөөд зөвлөх зэрэгтэй 3 багш, тэргүүлэх зэрэгтэй 13 багш, заах аргач зэрэгтэй 12 багш.

Сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр тогтмол улс, аймгийн дунджаас дээгүүр үнэлэгддэг ба 2025 онд нийт багш нарын 52% нь I-IV индексээр үнэлэгдсэн.



Энэ хичээлийн жил улсын төрөлжсөн олимпиадын 2-н даваанаас 4 багш 3-р байр хүрэл медаль, 1 сурагч 1-р байр алтан медаль, орон нутгийн төрөлжсөн олимпиадаас 1 багш 3-р байр хүрэл медаль, 1 сурагч 1-р байр алтан медаль, 2 сурагч 2-р байр мөнгөн медаль, 2 сурагч 3-р байр хүрэл медалийг тус тус хүртсэн.

Элсэлтийн ерөнхий шалгалтад сурагчдыг тогтмол амжилттай бэлтгэн оролцуулдаг бөгөөд өнгөрсөн хичээлийн жил 48 сурагч 7 судлагдахуунаар ЭЕШ өгч 87.5% нь их дээд сургуульд элсэн суралцсан.

Сурагчдын мэдлэг, авъяас, чадварыг нээн хөгжүүлэхээр нийт 20 төрлийн секц, дугуйлан, клубд давхардсан тоогоор 508 сурагч хичээллэж улс, аймгийн чанартай олон төрлийн уралдаан тэмцээнд амжилттай сайн оролцон 150 гаруй медаль хүртсэн.



Багш суралцагч, эцэг эхийн санаачилга дэмжлэгээр бид аймаг, бүсдээ жишиг болохуйц 2 цахим танхим, бага ангийн болон байгаль нийгмийн ухааны нийт 33 кабинет, биеийн тамир, урлагийн 3 заалыг сургалтын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулах бүрэн боломжтойгоор тохижуулж, сургалтын таатай орчинг бүрдүүлэн ажиллахаас гадна

сургуулийнхаа гадна талбайд волейболын стандартын талбай байгуулж, хичээлийн А, Б байрны автомашины зогсоолын зай талбай, хүртээмжийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулан ажилласнаар 2024 онд аймгийн боловсролын байгууллагуудаас **“Сургалтын орчин бүрдүүлэлт”** номинацийн эзэн сургуулиар шалгарч, БАТЛАМЖ гардан авсан.

Сургалт, хүмүүжлийн ажлыг амжилттай сайн зохион байгуулж, сурагчдын авъяас чадварыг нээн хөгжүүлснээр манай сургууль олон арван амжилтын эзэн болсон. Үүнд: **“Сургалтын орчин бүрдүүлэлт”** номинацийн эзэн, Монголын хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны тэмцээнд спортын 22 төрөлд амжилттай оролцож нийлбэр дүнгээр **гутгаар байр, Захиргаа, аж ахуйн ажилчдын “Спортын наадамд тэргүүн, дэд байр, “Шилдэг үйлдвэрчний эвлэлийн хороо”**.

#### ГУРАВ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН АНКЕТ

Төсөл санаачлагчийн овог нэр:	Д.Дэлгэрбаяр
Иргэний үнэмлэх, регистрийн дугаар:	ТЖ78120775
Албан тушаал	Сургуулийн захирал
Байгууллагын нэр	IV сургууль
Байгууллагын төрөл /сонгоно уу/: Сум, багийн захиргаа, <u>төсвийн байгууллага</u> Залуучуудын бүлэг Хувь хүн Эрдэмтэн судлаач	Төсвийн байгууллага
И-мэйл хаяг:	dekiduuji@gmail.com
Гар утас:	99077902, 99322020
Факс:	=
Хаяг:	Дархан сум 3-р баг IV сургууль
Хот, аймаг, сум, дүүрэг, баг, хороо	Дархан-Уул аймаг

#### ДӨРӨВ. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Боловсролын ерөнхий хуулийн 10.1.1.т Суралцагч нь эрүүл, аюулгүй, жөндөрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах, НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго”-ын 15 дахь заалтын “Хуурай газрын эко системийг хамгаалах, сэргээх болон тогтвортой хэрэглээг дэмжих, цөлжилттэй тэмцэх, хөрсний доройтлыг зогсоон, эргүүлэн сэргээх, биологийн төрөл зүйлийн усталтыг зогсоох”, “Алсын хараа–2050”-ийн зорилт 2.5. Зорилт 2.5. Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат

хүнсээр хангах, Дархан-Уул аймгийн ЗДТГ-аас дэвшүүлсэн “Ногоон Дархан-2032” хөтөлбөр, сургуулийн СТРАТЕГИ төлөвлөгөөний Зорилт 3.4 “Сургуулийн гадаад орчныг тохижуулах ногоон төгөл байгуулах” зорилт, 2025-2026 оны хичээлийн жилийн “Суралцагчдад эрүүл мэнд, сэтгэл зүй, хүүхэд хамгааллын үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлж, эрүүл, аюулгүй орчныг сайжруулах” зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү ажлын хүрээнд бид дараах үйл ажиллагаануудыг багш сурагчид, үйлчилгээний ажилчдынхаа нөөц боломжоор зохион байгуулсан. Үүнд:

- ✓ Сургуулийнхаа гадна талбайд хайлаас, нарс зэрэг нийт моддыг тарьж арчлан ургуулж байна.
- ✓ Биологийн мэргэжлийн багш нар болон 7-р ангийн багш суралцагчдынхаа санаачилгаар “Цэцэг” төслийг 3 дахь жилдээ амжилттай үр дүнтэй хэрэгжүүлж, хичээлийн шинэ жилийн нээлийн үйл ажиллагаагаа цэцгээр чимдэг.
- ✓ Нийтийн цэвэрлэгээг тогтмол хийж хог хаягдал, шарилжгүй цэвэр орчинг бүрдүүлдэг.
- ✓ Дунд, ахлах ангийн нийт багш суралцагчид хамран сургах тойргийнхоо голын эрэг дагуу 2 га газар үржүүлэн суулгасан олон төрлийн моднуудад цэнэг усалгаа хийж, модны тогоо цэвэрлэх ажилд 2 жил дараалан идэвхтэй оролцсон.
- ✓ Сургуулийнхаа план зургийг шинэчлэн, бага дунд ангийн сурагчдын дунд “Миний мөрөөдлийн сургууль” гар зургийн уралдаанаар дамжуулан сурагчдаасаа шинэ санааны төсөл, санаачилга хүлээж авсан зэрэг олон сайн үйл ажиллагаануудыг зохион байгуулж ирсэн.

Одоо манай сургуулийн хичээлийн А, Б байрны хог ангилан ялгаж хаях 4ш том хогийн сав байрлуулсан талбай болон бусад сул талбайууд нь цаг улирлын байдлаас шалтгаалан хог бохир үнэртэх, шавар шалбааг тогтох, тоос шороо босох зэргээр орчныг бохирдуулан, таагүй нөхцөл үүсгэж байна.

Ногоон байгууламж нь хотын агаарыг цэвэршүүлж, чийгшүүлэн, шороо тоосжилтыг багасгаж байдгаас гадна хүмүүсийн ажиллаж амьдрах тохитой нөхцөлийг бүрдүүлж, хотын экосистемийг зохицуулдгаараа өндөр ач холбогдолтой. Мөн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, мод, цэцэг нь орчны үзэмжийг сайжруулж, нүүрсхүчлийн хийг шингээн, хүчилтөрөгч ялгаруулснаар агаарын чанарыг сайжруулж, бохирдлыг бууруулахад нөлөөлснөөр хүний стрессийг багасгаж, сэтгэл санааг сайжруулан, нийгэм, эрүүл мэндийн олон асуудлыг шийдвэрлэхэд туслан, иргэдэд дасгал хөдөлгөөн хийх, амрах, нийгмийн харилцаанд оролцох олон сайхан боломжийг бүрдүүлж, эрүүл, аз жаргалтай амьдралын үндэс болдог.

Сургуулийн орчин нь хүүхэд бүр сурч хөгжихөд таатай, аюулгүй, хүүхдэд ээлтэй, хүчирхийлэлгүй орчин байх ёстой. Эдгээр хэрэгцээ шаардлагын дагуу сурагчдынхаа хүсэл

мөрөөдөл, эрүүл аюулгүй орчинд суралцах нөхцөлийг сайжруулан тэрхүү талбайд мод тарьж, зүлэгжүүлэн, ногоон байгууламж бий болгох зайлшгүй хэрэгтэй байна.

#### **ТАВ. ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

Сургуулийн гадна талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сурагчдын сурч, хөгжих эрүүл, ая тухтай, таатай орчинг бүрдүүлэх

#### **ЗУРГАА.ТӨСЛИЙН ЗОРИЛТ**

- Ногоон байгууламж байгуулах талбайг бэлтгэж, талбайд хөрс боловсруулалт хийнэ.
- Ногоон байгууламжинд хамгаалалтын хашаа хайс хийж, суурилуулна.
- Бэлтгэсэн талбайд зүлэгжүүлэлт хийж, гацуур мод тарина.
- Зүлэг, мод тарьсны дараа усалгаа, арчилгаа, хамгаалалтын ажил хийнэ.

#### **ДОЛОО. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Ногоон байгууламжийн ажил хийх баг байгуулах
- Сурагчдын дунд “Гоё сургууль” зургийн уралдаан зохион байгуулах
- Ногоон байгууламж хийх талбай сонгох, хэмжээ авах, талбайг бэлтгэх
- Сонгосон талбайд хөрс боловсруулалт хийх
- Ногоон байгууламжийн хамгаалалтын хашаа хайс хийх, суурилуулах
- Боловсруулалт хийгдсэн талбайд зүлэгжүүлэлт болон мод тарих ажил хийх
- Усалгаа, арчилгаа, хамгаалалтын ажил тогтмол хийх

#### **НАЙМ. ТӨСЛИЙН ҮР ДҮН**

- “Ногоон Дархан-2032” хөтөлбөрийн “Газрын хөрсийг хамгаалж, газрын доройтлоос сэргийлж, агаарын бохирдлыг бууруулах” гол зорилт хэрэгжинэ.
- Сургуулийн 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний зорилго, зорилт биелэнэ.
- Ногоон байгууламж нэмэгдсэнээр агаарыг цэвэршүүлж, чийгшүүлж, шороо тоосжилт багасгана.
- Сургуулийн өнгө, үзэмж сайжирч, эрүүл цэвэр, таатай орчин бүрдэнэ.
- Сурагчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх талбайтай болно.

## ЕС. ТӨСЛИЙН ТӨСӨВ

Талбайд тохижилт, ногоон байгууламжийн ажил хийх зардлын төсөв

№	Материалын нэр төрөл	Үзүүлэлт, төрөл зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Бүгд үнэ /төг/
Талбайд хөрс боловсруулалт хийх						
1	Бага оврын трактороор талбай тэгшлэх	loktus-752	цагаар	9	130,000	1,170,000
<b>Тарилтын талбай бэлтгэх зардлын дүн:</b>						<b>1,170,000</b>
талбайн Материалын зардал						
1	Зүлэгний үр	Орос согоовор	кг	70	35,000	2,450,000
2	Гацуур	1.8-2м өндөртэй	ш	11	350,000	3,850,000
3	Хар шороо	Хар шороо	мкуб	17	95,000	1,615,000
4	Элс	ширхэгтэй элс	мкуб	17	65,000	1,105,000
<b>Материалын зардлын нийт дүн</b>						<b>9,020,000</b>
Ногоон байгууламжийн хамгаалалтын хашаа хайс хийх, суурилуулах ажлын зардлын төсөв.						
1	Квадрат төмөр	40*40. 1.5мм	м	52	9,500	494,000
2	Ногоон тросс		м	300	2,500	750,000
3	Хомут		ш	50	1,500	75,000
4	Цемент		тн	1	450,000	450,000
5	Элс, хайрга	ширхэгтэй элс	мкуб	4	29,500	118,000
6	Будаг	ногоон 10л-тэй	л	10	14,500	145,000
7	Шингэлэгч	шилтэй	ш	2	6,500	13,000
8	Өнхөрүүш	солонгос дундын	ш	2	5,000	10,000
9	Багс		ш	2	3,500	7,000
10	Таслагчийн ир	Ф150-тай	ш	10	3,800	38,000
<b>Зардлын нийт дүн</b>						<b>2,100,000</b>
<b>Бүгд дүн</b>						<b>12,290,000</b>

## НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТАЛБАЙН ЗУРАГ



**ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН: ТӨСЛИЙН БАГ**

**2026 он**